

**НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН АХМАД НАСТАН, БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХАРИУЦСАН АЖИЛТАН
Д.АМАРЗАЯАГИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/ Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлти йн хувь
	1	2	3	4	5	6	7
НЭГ. “АХМАД НАСТНЫ АМЬЖИРГААГ ДЭМЖИЖ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭН НИЙГМИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛНЭ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	1.1.1. Ахмад настанд чиглэсэн олон талт арга хэмжээг зохион байгуулах	Хамрагдсан ахмадын тоо	Давхардсан тоогоор 43580	Хамрагдсан ахмадын тоо 12000	Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд: Олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр 350 эмэгтэй, Зэвсэгт хүчний 104 жил, Монгол цэргийн бахархлын өдөрт зориулсан хүндэтгэлийн арга хэмжээнд 200 ахмад, "Ахмадууд дуулж байна" дуун цэнгүүнийг бүс бүр сар болгон зохион байгуулахад нэг удаад 38-50 хүн хамрагдаж нийт 5 удаагийн арга хэмжээнд 200 ахмад, Ахмад настны тухай хуулийг сурталчлан таниулах зорилгоор 5 багц сэдэв бүхий сургалтыг Ахмадын ордоны сургалт, мэдээллийн танхим болон багуудын Иргэний танхим, Соёлын төвүүдэд 26 удаа зохион байгуулахад нийт 885 ахмадыг хамруулсан. Мөн сургагч багш нар НБХ, ТББ, ХХҮГ-уудтай хамтран 1397 ахмадын оролцоотой сургалтыг зохион байгуулж, “Цахим ахмад” хөтөлбөрийн хүрээнд 25 ахмадыг “Хурдан клуб”-т суралцуулж байна. Нийт 36 удаагийн сургалт, мэдээллийн арга хэмжээг зохион байгуулахад 2307 ахмад хамрагдсан.	2025.01.01 2025.12.31	100

					Аймгийн аварга шалгаруулах волейболын тэмцээнд 182 ахмад, софт волейболд 5 бүсийн 20 тамирчин, шатар, даамны тэмцээнд 52 ахмад тус тус хамрагдсан бол дээрх 47 удаагийн арга хэмжээнүүдэд 5593 ахмад хамрагдсан байна. Хүн амын бүлгүүд, Нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр Баян-Өндөр сумын 100 ахмад настныг өдрийн үйлчилгээнд хамруулсан. Сар шинийн баярыг тохиолдуулан 70-с дээш насны 3030 ахмадад Засаг даргын хүндэтгэл үзүүлсэн байна. Хөтөлбөрийн хүрээнд дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр хөтөлбөр 100 хувийн хэрэгжилттэй байна.		
2.	1.1.2. Анхдагч илгээлтийн эзэд болон ахмад настанд зориулсан хөтөлбөр хэрэгжүүлэх	Хэрэгжилтийн хувь	-	Хэрэгжилтийн хувь 40%	Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд: 2025 оны 6 дугаар сарын байдлаар МАНЗ-Баатар холбоо, төрийн байгууллагуудын Соёмбо холбоо, Эрдэнэтийн овооны анхдагч илгээлтийн эздийн холбоо, Барилгачин дайчдын холбоо, Залуу насаа эргэн дурсахуй холбоо, Анхдагч багш нарын Эрдэм холбоо, Далан гурав далан найм холбооны гишүүдийн дунд зохион байгуулах олон талт үйл ажиллагааны зардалд 31,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Тус дэмжлэгийн хүрээнд хүнд нөхцөлд амьдарч буй 11 анхдагчид тусламж, хэвтрийн өвчтэй 32 анхдагчид гэрийн эргэлт, ахмадын сувилалд 43, өдөр өнжүүлэх үйл ажиллагаанд 21 анхдагч тус тус хамрагдсан. Тэмдэглэлт	2025.01.01 2025.12.31	100

					өдрүүдийн арга хэмжээг 3, сургалтын үйл ажиллагаа 2, туршлага судлах уулзалт аялал 1, спортын урлагийн тэмцээн тус бүр 2 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 1100 гаруй анхдагч, ахмадууд хамрагдсан байна. Хөтөлбөр 100 хувийн хэрэгжилттэй байна.		
ХОЁР. "ЭРДЭНЭТ СПОРТ ЦОГЦОЛБОР"- ЫГ ШИНЭЭР АШИГЛАЛТАД ОРУУЛАН, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭГ ИРГЭДЭД СУРТАЛЧИЛЖ ИДЭВХТЭЙ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГИЙГ ХЭВШҮҮЛНЭ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1	1.2.1. Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчдын тоог нэмэгдүүлж, тэмцээн уралдаанд амжилттай оролцуулах	Гэрээт дасгалжуулагчдын тоо	-	Гэрээт дасгалжуулагчдын тоо 1	Тайлант оны эхний хагас жилд Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ 16 багийн 3 багт 14 тамирчин нэмэгдэж, 196 өсвөрийн тамирчин бэлтгэл сургуулилалт хийж байна.Өсвөрийн шигшээ багуудаас хүндийн өргөлт, хөнгөн атлетикийн шигшээ багуудад гэрээт дасгалжуулагч ажиллуулсан. Монголын хүүхдийн спортын өвлийн VIII наадамд Орхон аймгаас өвлийн спортын 6 төрөлд 75 тамирчин, 10 дасгалжуулагчдыг бэлтгэн оролцуулж, багийн дүнгээр 2-р байр, зуны төрлийн анхан шатны тэмцээнийг спортын 20 төрлөөр зохион байгуулж, 2146 тамирчин хамруулан зохион байгуулсан.Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын шигшээ тэмцээнд спортын 30 төрөлд 297 тамирчин, 51 дасгалжуулагчдыг бэлтгэн оролцуулж, алтан медаль 15, мөнгөн медаль 15, хүрэл медаль 25, нийт 55 медаль авч 21 аймгийн багийн нийлбэр дүнгээр тэргүүн байранд шалгарсан амжилтыг үзүүлсэн. Тамирчдыг тэмцээн уралдаанд оролцуулахад орон нутгийн төсвийн 219,1 сая төгрөгийг зарцуулсан.	2025.01.01 2025.12.31	100

2	1.2.2. Цахим болон хотын (урбан) спортын төрлүүдээр тэмцээн уралдаан зохион байгуулах	Зохион байгуулагдсан тэмцээний тоо	Зохион байгуулагдсан тэмцээний тоо 2	Зохион байгуулагдсан тэмцээний тоо 2	Тайлант оны эхний хагас жилд цахим спортоор 1 удаа, хотын (урбан) спортын төрлүүдээс сагсан бөмбөгийн 3х3 төрлөөр 4 удаагийн тэмцээнд 480, нийт 5 удаагийн тэмцээнд 520 өсвөрийн тамирчдыг оролцуулан зохион байгуулсан. Тэмцээн уралдаанд орон нутгийн төсвийн 1,1 сая төгрөгийг зарцуулсан.	2025.01.01 2025.12.31	100
3	1.2.3. Хийн болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөнийг сурталчилж, "Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшье" аяныг аймгийн иргэд болон ААНБ-уудын дунд өрнүүлэх	Дасгал хөдөлгөнд хамруулах иргэдийн хувь	Дасгал хөдөлгөнд хамруулах иргэдийн хувь 24.6%	Дасгал хөдөлгөнд хамруулах иргэдийн хувь 12.75	Тайлант оны эхний хагас жилд аймгийн хэмжээнд хийн болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөнийг сурталчилж, "Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшье" аяны хүрээнд 49 арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 12,414 мянган иргэдийг хамруулсан. Тус арга хэмжээнүүдэд улсын төсвийн 12,2 сая төгрөг, орон нутгийн төсвийн 11,4 сая төгрөгийг тус тус зарцуулсан.	2025.01.01 2025.12.31	90
4	1.2.4. Үндэсний болон багийн спортын төрлүүдээр иргэдийн спортын их наадмыг шат дараатай зохион байгуулах		Зохион байгуулагдсан тэмцээний тоо 7	Зохион байгуулагдсан тэмцээний тоо 8	Үндэсний болон багийн спортын төрлүүдээр "Иргэдийн спортын наадам"-ыг 2024 онд Баян-Өндөр, Жаргалант сумдын ЗДТГ-тай хамтран тайланд онд "Иргэдийн спортын наадам"-ыг багийн болон үндэсний спортын 8 төрлөөр зохион байгуулж, 1015 иргэн оролцсон. Тэмцээн зохион байгуулахад орон нутгийн төсвийн 25,0 сая төгрөгийг зарцуулсан. 2025 оны 10-11 сард зохион байгуулахаар төлөвлөсөн.	2025.01.01 2025.12.31	Хэрэгжих хугацаа болоогүй.

		Зохион байгуулагдс ан тэмцээний тоо					
ГУРАВ. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
6	1.3.1. ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Хэрэгжилтийн хувь	Биелэлтийг хагас жилийн байдлаар гаргаж тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна.	Биелэлтийг жилийн эцсийн байдлаар гаргаж тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна.	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж 2025 оны 1-р сард батлуулсан. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлж ажилласан.	2025.01.01 2025.12.31	100
7	1.3.2. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай	Ёс зүйн болон бусад зөрчил гаргаагүй байх	Хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байх	Хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байх	Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийн дагуу шаардлагатай, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	2025.01.01 2025.12.31	100

	хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.						
8	1.3.3. Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх	Шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо	Өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэж хариуг өгсөн байх	Өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэж хариуг өгсөн байх	Иргэдээс ирүүлсэн 9 өргөдөл, байгууллагууд спорт холбоодоос ирүүлсэн 68 хүсэлтийг шийдвэрлэж холбогдох арга хэмжээг авч буцаан хариу өгсөн.	2025.01.01 2025.12.31	100
9	1.3.4. Засаг дарга, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэг, комисст ажиллах, өгөгдсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэх	Комисс, ажлын хэсэгт ажилласан тоо	-	Шийдвэрийн дагуу ажиллах	Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын шуурхай хурлаас ирүүлсэн 6 удаагийн үүрэг даалгаврыг биелүүлж, хариуг хүргүүлсэн.	2025.01.01 2025.12.31	100
10	1.3.5. ТАХ-ын спорт заалны үйл ажиллагаанд хяналт тавих, шаардлагатай асуудлыг удирдлагад танилцуулан шийдвэрлэх	Үйл ажиллагаа хэвийн үргэлжилэх	Шийдвэрийн дагуу ажиллах	Шийдвэрийн дагуу ажиллах	Спорт заал 2025 оны батлагдсан хуваарийн дагуу үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Нийт 23 байгууллага 7 хоног бүр спорт зааланд хичээллэж байа. Мөн Билэгт-Өргөө сургууль болон волейболын 3 дугуйлан тогтмол хичээл сургалтын үйл ажиллагаа явуулж байна.	2025.01.01 2025.12.31	100

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт


Д/Д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Сар шинийн хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад анхаарах	Арга хэмжээг зохион байгуулах	-	Үйл ажиллагаа зохион байгуулалттай байна.	Хаврын тэргүүн сарын шинийн нэгэн Сар шинийн баярыг тохиолдуулан Орхон аймагт амьдарч буй 70 ба түүнээс түүнээс дээш насны ахмад настанд хүндэтгэл үзүүлэх ажлыг аймгийн ИТХ-ын төлөөлөлч нартай хамтран зохион байгууллаа.70-89 настай ахмад настны хүндэтгэлд зориулсан	2025.01.10 2025.02.25	100

					бэлэн мөнгийг Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ-т шилжүүлж иргэдийн дансанд шилжүүлсэн. Цаг тооны бичгийг багуудын ажлын албаар дамжуулан хүргүүлсэн. 90-94 настай ахмад настны хүндэтгэлийн зүйлийг аймгийн ИТХ-ын ажлын албаар, 95 дээш настай ахмад настнуудын хүндэтгэлийг ЗДТГ-ын дарга нар болон аймгийн удирдлагуудаар дамжуулан иргэдэд хүргүүлэх ажил хийгдсэн. Нийт 3030 ахмад настан хамрагдав.		
2	Монголын хүүхдийн спортын өвлийн VIII наадамд Орхон аймагт зохон байгуулах, бэлтгэл хангах	Арга хэмжээг зохион байгуулах	-	Үйл ажиллагаа зохион байгуул агдсан байна.	Монголын хүүхдийн спортын өвлийн VIII наадамд Орхон аймгаас өвлийн спортын 6 төрөлд 75 тамирчин, 10 дасгалжуулагчдыг бэлтгэн оролцуулж, багийн дүнгээр 2-р байр, зуны төрлийн анхан шатны тэмцээнийг спортын 20 төрлөөр зохион байгуулж, 2146 тамирчин хамруулан зохион байгуулсан.	2025.01.10 2025.02.15	100
3	Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын шигшээ тэмцээний бэлтгэл хангах, оролцох	Арга хэмжээг зохион байгуулах	-	Үйл ажиллагаа зохион байгуул агдсан байна.	Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын шигшээ тэмцээн 2025 оны 05 дугаар сарын 26-наас 06 дугаар сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Манай аймгаас спортын 30 төрөлд 297 тамирчин, 51 дасгалжуулагчдыг бэлтгэн оролцуулж, алтан медаль 15, мөнгөн медаль 15, хүрэл медаль 25, нийт 55 медаль авч 21 аймгийн багийн нийлбэр дүнгээр тэргүүн байранд шалгарсан амжилтыг үзүүлсэн. Тус тэмцээний зардалд орон нутгийн төсвийн 167,5 сая төгрөг зарцуулсан.	2025.05.10 2025.06.06	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7

Зорилт 1.							
1.	2.1.1. Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг чадвараа дээшлүүлэх холбогдох хууль тогтоомжийг судлах, сургалтад хамрагдах	Сургалтан д хамрагдсан байна.	-		Хэрэгжүүлж буй хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрүүдийг чиглэл болгон ажиллаж байна. -Төрийн албаны Зөвлөлөөс төрийн албан хаагчийн гүйцэтгэл үр дүн, төрийн байгуулагуудын бүтээмжийг дэмжих сургалтууд, -Биеийн тамир спортын улсын хорооноос зохион байгуулсан 2 удаагийн цахим сургалтанд тус тус хамрагдсан.	2025.01.01 2025.12.31	100

ТАЙЛАН ГАРГАСАН:
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН АХМАД НАСТАН, БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ХАРИУЦСАН АЖИЛТАН  Д.АМАРЗАЯА